ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СНАГ-2024/318/НА-СТА-ТХН**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2023 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261665 Цахим хаяг: naranchimeg.ts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Лхагвацэнд<br>Утас: 261885 Цахим хаяг: lkhagvatsendb@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Д.Цэгмиддорж<br>Утас: 263533 Цахим хаяг:tsegmiddorjd@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн<br>Ерөнхий захирал: Ц.Жигдэн<br>Утас: 70005401 Цахим хаяг:info@btdalaivanaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.29 № 07/604
танай ____________-ны № ______________-т

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Д.АВИРМЭД ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон бидний тогтоосон 220,819.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Төслийн нэгж буюу захиалагч нь 2021 онд DDCD-BKH болон ASKG-BKH гэрээний дугаартай барилгын ажлыг эхлүүлсэн байна. Гүйцэтгэгч талуудаас үнийн өсөлт болон материал, ажиллах хүчний цалин, тээвэр шатахуун, машин механизмын зардлыг багтаасан шинэчилсэн төсөвт өртгөөр хийх тухай хүсэлт гаргасан ба захиалагч талын зүгээс шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүйгээс 2022, 2023 онуудад тус гэрээт ажил зогсонги байдалд орж огт ажил хийгээгүй байна. Гүйцэтгэгч нараас үнийн өсөлт болон материал, ажиллах хүчний цалин, тээвэр шатахуун, машин механизмын зардлын зөрүү 6,552,127.4 мянган төгрөг нэхэмжилсэн,
- Төслийн үр дүнд бий болсон 169,687,775.1 мянган төгрөгийн хөрөнгийг эзэмших байгууллагын данс бүртгэлд шилжүүлэх шийдвэр гараагүй байхад хөрөнгийг

ашиглуулахаар байгууллагуудад хариуцуулсан зэрэг алдаа, зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.2, 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.4 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төслийн үйл ажиллагааны 2023 оны урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийслэлийн төсвөөс 419,495.4 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 357,712.0 мянган төгрөг буюу 87.2 хувьтай байна. Төсөл нь нийслэлийн санхүүжилтийг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт тусдаа санхүүгийн тайлангаар тайлагнадаг тул төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгадаггүй байна.

Төслийн хүрээнд 2020-2021 онд ашиглалтад орж Улсын комиссын акт нь гарсан 21,047,294.2 мянган төгрөгийн барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид шилжүүлж бүртгэлээс хассан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд төслийн бүрэлдэхүүн, хөтөлбөрийн хэрэгжилтэд Азийн хөгжлийн банкнаас 51,398,722.6 мянган төгрөг, Нийслэлийн Засаг Даргын Тамын Газраас 11,574,131.4 мянган төгрөг, нийт 62,972,854.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлж зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төсөл нь хэрэгжсэнээр дараах 4 үр дүнд хүрэхээр боловсруулагдсан: (i) тэргүүлэх ач холбогдол бүхий дэд төвүүдэд авто зам болон хотын дэд бүтцийн үйлчилгээ өргөжиж, тэдгээрийн хоорондын холболт сайжирна; (ii) зорилтот хэсгүүд дэх эдийн засгийн болон төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ; (iii) дэд бүтцийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааны үр дүн сайжирна; (iv) хот байгуулалт, хөтөлбөрийн менежмент, үйлчилгээг хүргэх чиглэлээр институци болон чадавх бэхжинэ. Хөтөлбөр гурван шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 62.2 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй

Азийн Хөгжлийн Банкны ажлын хэсэг төслийн хэрэгжилтэд хяналт тавин 2023 оны 03-р сард ажилласан бөгөөд төслийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлуудыг холбогдох талуудтай хэлэлцэн дээрх тулгамдаад байгаа нөхцөл байдлаас шалтгаалан төслийн хөрөнгө оруулалтуудыг хэрхэн дахин хуваарилах хөтөлбөрийн хугацааг сунгах шийдвэрүүдийг гарган хөтөлбөрийн хүсэлтийг Азийн Хөгжлийн Банкны захирлуудыг зөвлөлд гаргаж төслийн хэрэгжих хугацааг 2026 оны 12 сарын 11 хүртэл сунгаад байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

***2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН***

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **405,724,411,118.93** | **468,500,365,089.48** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **28,059,127,080.94** | **23,078,623,414.10** |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **28,059,127,080.94** | **23,078,623,414.10** |
| **31210** | **Төгрөг** | **455,931,422.22** | **490,231,169.82** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 455,931,406.20 | 490,231,169.82 |
| **31220** | **Гадаад валют** | **27,603,195,658.72** | **22,588,392,244.28** |
| 31221 | Төрийн сангийн харилцах | 27,579,690,259.46 | 22,565,118,241.43 |
| 31223 | Арилжааны банк дахь харилцах | 23,505,399.26 | 23,274,002.85 |
| **33** | **АВЛАГА** | **7,987,288.56** | **7,977,288.56** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 10,000.00 | - |
| **33500** | **Бусад авлага** | **7,977,288.56** | **7,977,288.56** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 7,977,288.56 | 7,977,288.56 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **334,548,457.21** | **334,548,457.21** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 334,548,457.21 | 334,548,457.21 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **391,326.05** | **10,757,113.75** |
| 35470 | Бусад хангамжийн материал | 391,326.05 | 10,757,113.75 |
| **360** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | **377,322,356,966.17** | **445,068,458,815.86** |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө | 377,322,356,966.17 | 445,068,458,815.86 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **52,358,904.75** | **27,810,910.11** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **52,358,904.75** | **27,810,910.11** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **52,358,904.75** | **27,810,910.11** |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 113,950,000.00 | 113,950,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (85,462,499.88) | (96,857,499.84) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 84,381,500.00 | 84,381,500.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (78,534,833.28) | (84,381,499.92) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 73,063,279.90 | 73,063,279.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (55,038,541.99) | (62,344,870.03) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **405,776,770,023.68** | **468,528,175,999.59** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **26,891,124,676.80** | **45,322,195,648,61** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **26,891,124,676.80** | **45,322,195,648.61** |
| **41300** | **Өглөг** | **78,798.70** | **23,432,177,042.00** |
| 41310 | Ажиллагсадтай холбогдсон өглөг | 75,714.53 | 75,714.53 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 3,084.17 | 23,431,835,327.47 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 266,000.00 |
| **41400** | **Урьдчилж орсон орлого** | **26,891,045,878.10** | **21,890,018,606.61** |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 26,891,045,878.10 | 21,890,018,606.61 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| 42200 | Урт хугацаат зээл | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **378,885,645,346.88** | **423,205,980,350.98** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **378,885,645,346.88** | **423,205,980,350.98** |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **378,868,105,346.88** | **423,205,980,350.98** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 275,802,621,577.84 | 378,868,105,346.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 103,065,483,769.04 | 44,320,335,004.10 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 17,540,000.00 | 17,540,000.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **405,776,770,023.68** | **468,528,175,999.59** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

***2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН***

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **118,439,839,299.71** | **66,138,189,616.14** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **89,322,747,020.71** | **54,564,058,259.14** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **89,322,747,020.71** | **54,564,058,259.14** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 89,305,018,975.71 | 54,507,747,159.14 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 82,621,709,395.31 | 51,398,722,572.24 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,683,309,580.40 | 3,109,024,586.90 |
| 120009 | Бусад орлого | 17,728,045.00 | 56,311,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **29,117,092,279.00** | **11,574,131,357.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **29,117,092,279.00** | **11,574,131,357.00** |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 29,117,092,279.00 | 11,574,131,357.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **18,989,719,359.62** | **22,081,972,986.16** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **18,989,719,359.62** | **22,081,972,986.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **18,989,719,359.62** | **22,081,972,986.16** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,029,263,767.98** | **970,307,639.38** |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,029,263,767.98 | 970,307,639.38 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **460,812.03** | **258,803.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 460,812.03 | 258,803.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **17,959,994,779.61** | **21,111,406,543.78** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,935,446,784.97 | 21,086,858,549.14 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,547,994.64 | 24,547,994.64 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **99,450,119,940.09** | **44,056,216,629.98** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **4,196,543,838.08** | **488,168,885.86** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 4,196,543,838.08 | 488,168,885.86 |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **581,180,009.13** | **224,050,511.74** |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | 581,180,009.13 | 224,050,511.74 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **103,065,483,769.04** | **44,320,335,004.10** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

***2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН***

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **41,469,787,783.63** | **22,480,638,221.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **41,469,787,783.63** | **22,480,638,221.40** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **41,469,787,783.63** | **22,480,638,221.40** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 41,469,787,783.63 | 22,480,638,221.40 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 41,241,962,716.12 | 22,424,327,121.40 |
| 120009 | Бусад орлого | 227,825,067.51 | 56,31,100.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **15,489,980.43** | **42,610,596.56** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **15,489,980.43** | **42,610,596.56** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **15,489,980.43** | **42,610,596.56** |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 460,812.25 | 258,803.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,029,168.18 | 42,351,793.56 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **41,454,297,803.20** | **22,438,027,624.84** |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-** | **-** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **(39,395,206,771.67)** | **(27,418,531,291.68)** |
| **14** | **Бусад эх үүсвэр** | **4,241,309,287.86** | **184,410,048.12** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 4,241,309,287.86 | 184,410,048.12 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **43,636,516,059.53** | **27,405,013,528.85** |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 43,636,516,059.53 | 27,405,013,528.85 |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **-** | **197,927,810.95** |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | - | 197,927,810.95 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **2,059,091,031.53** | **(4,980,503,666.84)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 26,000,036,049.41 | 28,059,127,080.94 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 28,059,127,080.94 | 23,079,623,414.10 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

***2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН***

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **17,540,000.00** | **275,802,621,577.84** | **275,820,161,577.84** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **17,540,000.00** | **275,802,621,577.84** | **275,820,161,577.84** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 103,065,483,769.04 | 103,065,483,769.04 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **17,540,000.00** | **378,868,105,346.88** | **378,885,645,346.88** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **17,540,000.00** | **378,868,105,346.88** | **378,885,645,346.88** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 44,320,335,004.10 | 44,320,335,004.10 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **17,540,000.00** | **423,188,440,350.98** | **423,205,980,350.98** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

***2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН***

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **46,708,365,000.00** | **46,997,914,276.20** | **289,549,276.20** | **100.62** |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 46,708,365,000.00 | 46,997,914,276.20 | 289,549,276.20 | 100.62 |
| **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **46,708,365,000.00** | **46,997,914,276.20** | **289,549,276.20** | **100.62** |
| Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 46,708,365,000.00 | 46,997,914,276.20 | 289,549,276.20 | 100.62 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **46,708,365,000.00** | **46,997,914,276.20** | **289,549,276.20** | **100.62** |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **46,708,365,000.00** | **46,997,914,276.20** | **289,549,276.20** | **100.62** |
| Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 46,708,365,000.00 | 46,997,914,276.20 | 289,549,276.20 | 100.62 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **28,059,127,080.94** | | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **23,079,623,414.10** | | |
| Байгууллагын тоо | 1 | 1 | - | 100.0 |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **26** | **24** | **2** | 92.3 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 25 | 23 | 2 | 92.3 |

## Гурав. Аудитын илрүүлэлт

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитаар нийт 211,301.6 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулга хийгээгүй, 41,595.1 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд тендерийн баримт бичиг борлуулсны орлого 37,009.5 мянган төгрөгийг тендертэй холбоотойгоор 36,329.6 мянган төгрөгийг зарцуулж 679.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тус зарцуулагдаагүй үлдэгдлийг Төсвийн тухай хуулийн дагуу төвлөрүүлээгүй байна. | 1 | 679.9 | | | | | | | 1 | 679.9 | | |
| Улаанбаатар хотын иргэдийн орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөлд оролцогчдын хооронд байгуулсан №2019/02 тоот гурвал талт гэрээ байгуулсан байна. Тус гэрээгээр иргэн Б.Батхандын газар болон үл хөдлөх хөрөнгийн эрхийг 39 м.кв 2 өрөө Орон сууцаар сольж, шилжүүлэхээр тохиролцсон байна. Б.Батханд нь 39 м.кв 2 өрөө байраа 3 өрөө 54 м.кв болгон сольж үнийн зөрүүг 18,000.0 мянган төгрөгийг төслийн нэгжийн дансанд шилжүүлснийг орлогоор бүртгэж | 1 | 18,000.0 | | | | | | | 1 | 18,000.0 | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| тайлагнасан ба Төсвийн тухай хуулийн дагуу төвлөрүүлээгүй байна. | | | | | | | | | | | | |
| Улсын комиссын акт нь гарсан боловч Нийслэлийн Засаг Даргын Захирамжаар Нийслэлийн өмчид шилжүүлэн бүртгэх 169,687,775.1 мянган төгрөгийн хөрөнгө төслийн нэгжийн данс бүртгэлд бүртгэлтэй байна. Тус хөрөнгүүдийг балансаас балансад шилжүүлэн бүртгэх талаар Төслийн нэгжээс Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар болон Нийслэлийн Өмчийн Харилцааны Газарт удаа дараа албан тоот өгсөн боловч Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тухайн бий болсон хөрөнгийн ээлийг Нийслэлийн өмчийн байгууллагууд төлөх эсэхийг шийдвэрлээгүйн улмаас хөрөнгийг данс бүртгэлээс шилжүүлээгүй байна. | 1 | 169,687,775.1 | | | | | | | 1 | 169,687,775.1 | | |
| "Цаст констракшн" ХХК нь ASKG-BKH дугаартай цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гэрээг 2021.02.09-ны өдөр байгуулж, гэрээний нийт дүн 3,999,714.1 мянган төгрөг, гүйцэтгэх хугацааг 2021.02.09-2022.05.09-ны өдөр байхаар тусгасан боловч 2023.12.31-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 17.2 хувьтай байх бөгөөд 2022-2023 онд барилгын ажил огт хийгдээгүй, гэрээг 2022.05.09-с хойш дахин сунгагдаагүй ба 2023.12.31-ны өдрийн байдлаар нийт 832,026.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Мөн Гүйцэтгэгчийн зүгээс ковид-19 цар тахлын улмаас хил, гааль хаагдсанаас үүдсэн барилгын бараа материал, цалин, тээвэр шатахуун, машин механизмтай холбоотой үнийн өсөлт тооцуулах хүсэлт гаргаж тус ажлыг 6,969,797.1 мянган төгрөгийн шинэчилсэн төсөвт өртгөөр гүйцэтгэх боломжтой тухайгаа төслийн нэгжид 2023.03.30-ны | 1 | 2,970,083.0 | | | | | | | | | 1 | 2,970,083.0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| өдийн 23/31 тоот албан бичгээр мэдэгдсэн байна.Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс дээрх төсвийн нэмэгдэл зөрүү 2,970,083.0 мянган төгрөгийг шийдвэрлэх боломжгүй, зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг шийдвэрлэх боломжтойг илэрхийлсэн боловч гүйцэтгэгчийн зүгээс хүлээн зөвшөөрөөгүй байна. Монгол Улсын Сангийн яам болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан 2022.07.08-ны өдрийн “ Санамж бичиг”-т давтагдашгүй хүчин зүйл ангилалд гэрээт ажлын зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг тооцож үзнэ гэж заасан, мөн Монгол Улсын Их Хурлын 88 дугаар тогтоол, Барилга Хот Байгуулалтын Сайдын баталсан 75 дугаар түр журмаар зөвхөн барилгын материалын үнэд магадлал хийж үнийн өсөлтийг тооцуулах чиглэл өгсөн ба Төсөл хэрэгжүүлэгч нэгж болон гүйцэтгэгч нарын төлөөлөл 2021 оноос хойш дээрх тогтоол, журмын дагуу зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг тооцуулах талаар уулзалтууд хийсэн боловч тодорхой үр дүн гараагүй, барилгын ажил зогсонги байна. | | | | | | | | | | | | |
| “Тэш Агь Констракшн” ХХК болон “Ай Ди Си Проперти” ХХК-ын түншлэл нь “Баянхошуу дэд төв дэх олон нийтийн хөгжлийн төвийн барилга угсралтын ажил” DDCD-BKH гэрээг 2021.02.25-ны өдөр байгуулж, гэрээний дүн 2,940,919.2 мянган төгрөг, гүйцэтгэх хугацааг 2021.02.25-2022.05.25-ны өдөр байхаар тусгасан боловч 2023.12.31-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 28 хувьтай бөгөөд тайлант онд барилгын ажил огт хийгдээгүй, гэрээг 2022.05.25-с хойш дахин сунгагдаагүй ба 2023.12.31-ны өдрийн байдлаар нийт 533,837.7 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Гүйцэтгэгчийн зүгээс ковид-19 цар тахлын | 1 | 3,582,044.4 | | | | | | | | | 1 | 3,582,044.4 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| улмаас хил, гааль хаагдсанаас үүдсэн барилгын бараа материал, цалин, тээвэр шатахуун, машин механизмтай холбоотой зардлаар үнийн өсөлт тооцуулах хүсэлт гаргаж тус ажлыг 6,522,963.6 мянган төгрөгийн шинэчилсэн төсөвт өртгөөр гүйцэтгэх боломжтой тухайгаа төслийн нэгжид 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдийн 23/31 тоот албан бичгээр мэдэгдсэн байна. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс дээрх төсвийн нэмэгдэл зөрүү 3,512,044.3 мянган төгрөгийг шийдвэрлэх боломжгүй, зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг шийдвэрлэх боломжтойгоо илэрхийлсэн боловч гүйцэтгэгчийн зүгээс хүлээн зөвшөөрөөгүй байна.Монгол Улсын Сангийн яам болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан 2022.07.08-ны өдрийн “ Санамж бичиг”-т давтагдашгүй хүчин зүйл ангилалд гэрээт ажлын зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг тооцож үзнэ гэж заасан, мөн Монгол Улсын Их Хурлын 88 дугаар тогтоол, Барилга Хот Байгуулалтын Сайдын баталсан 75 дугаар түр журмаар зөвхөн барилгын материалын үнэд магадлал хийж үнийн өсөлтийг тооцуулах чиглэл өгсөн ба Төсөл хэрэгжүүлэгч нэгж болон гүйцэтгэгч нарын төлөөлөл 2021 оноос хойш дээрх тогтоол, журмын дагуу зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг тооцуулах талаар уулзалтууд хийсэн боловч тодорхой үр дүн гараагүй, барилгын ажил зогсонги байна. | | | | | | | | | | | | |
| Тайлант онд 23,431,835.3 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Энэ нь тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна. | 1 | 23,431,835.3 | | | | | | | | | 1 | 23,431,835.3 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийслэлийн санхүүжилтийн орлого 11,574,131.3 мянган төгрөг, тендерийн баримт бичиг борлуулсны орлого 37,009.5 мянган төгрөгийг тус тус цахим төлбөрийн баримтыг системд бүртгээгүй байна. | 1 | 11,611,140.8 | | | | | | | | | 1 | 11,611,140.8 |
| Дүн | 7 | 211,301,558.6 | | | | | | | 3 | 169,706,455.0 | 4 | 41,595,103.6 |

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 211,301,558.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 18,679.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 169,678,775.1 мянган төгрөгийн албан шаардлага, 41,595,103.6 мянган төгрөгийн зөвлөмж бэлтгэн өгөв.

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд тендерийн баримт бичиг борлуулсны орлого 37,009.5 мянган төгрөгийг тендертэй холбоотойгоор 36,329.6 мянган төгрөгийг зарцуулж 679.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тус зарцуулагдаагүй үлдэгдлийг Төсвийн тухай хуулийн дагуу төвлөрүүлээгүй байна. | 1 | 679.9 | 1 | 679.9 | | | | | | | | |
| Улаанбаатар хотын иргэдийн орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөлд оролцогчдын хооронд байгуулсан №2019/02 тоот гурвал талт гэрээ байгуулсан байна. Тус гэрээгээр иргэн Б.Батхандын газар болон үл хөдлөх | 1 | 18,000.0 | 1 | 18,000.0 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хөрөнгийн эрхийг 39 м.кв 2 өрөө Орон сууцаар сольж, шилжүүлэхээр тохиролцсон байна. Б.Батханд нь 39 м.кв 2 өрөө байраа 3 өрөө 54 м.кв болгон сольж үнийн зөрүүг 18,000.0 мянган төгрөгийг төслийн нэгжийн дансанд шилжүүлснийг орлогоор бүртгэж тайлагнасан ба Төсвийн тухай хуулийн дагуу төвлөрүүлээгүй байна. | | | | | | | | | | | | |
| Улсын комиссын акт нь гарсан боловч Нийслэлийн Засаг Даргын Захирамжаар Нийслэлийн өмчид шилжүүлэн бүртгэх 169,687,775.1 мянган төгрөгийн хөрөнгө төслийн нэгжийн данс бүртгэлд бүртгэлтэй байна. Тус хөрөнгүүдийг балансаас балансад шилжүүлэн бүртгэх талаар Төслийн нэгжээс Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар болон Нийслэлийн Өмчийн Харилцааны Газарт удаа дараа албан тоот өгсөн боловч Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тухайн бий болсон хөрөнгийн зээлийг Нийслэлийн өмчийн байгууллагууд төлөх эсэхийг шийдвэрлээгүйн улмаас хөрөнгийг данс бүртгэлээс шилжүүлээгүй байна. | 1 | 169,687,775.1 | | | 1 | 169,687,775.1 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| "Цаст констракшн" ХХК нь ASKG-BKH дугаартай цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гэрээг 2021.02.09-ны өдөр байгуулж, гэрээний нийт дүн 3,999,714.1 мянган төгрөг, гүйцэтгэх хугацааг 2021.02.09-2022.05.09-ны өдөр байхаар тусгасан боловч 2023.12.31-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 17.2 хувьтай байх бөгөөд 2022-2023 онд барилгын ажил огт хийгдээгүй, гэрээг 2022.05.09-с хойш дахин сунгагдаагүй ба 2023.12.31-ны өдрийн байдлаар нийт 832,026.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Мөн Гүйцэтгэгчийн зүгээс ковид-19 цар тахлын улмаас хил, гааль хаагдсанаас үүдсэн барилгын бараа материал, цалин, тээвэр шатахуун, машин механизмтай холбоотой үнийн өсөлт тооцуулах хүсэлт гаргаж тус ажлыг 6,969,797.1 мянган төгрөгийн шинэчилсэн төсөвт өртгөөр гүйцэтгэх боломжтой тухайгаа төслийн нэгжид 2023.03.30-ны өдийн 23/31 тоот албан бичгээр мэдэгдсэн байна.Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс дээрх төсвийн нэмэгдэл зөрүү 2,970,083.0 мянган төгрөгийг шийдвэрлэх боломжгүй, зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг шийдвэрлэх боломжтойг илэрхийлсэн боловч гүйцэтгэгчийн зүгээс хүлээн зөвшөөрөөгүй байна. Монгол Улсын Сангийн яам болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан 2022.07.08-ны өдрийн “ Санамж бичиг”-т давтагдашгүй хүчин зүйл ангилалд гэрээт ажлын зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг тооцож үзнэ гэж заасан, мөн Монгол Улсын Их Хурлын 88 дугаар тогтоол, Барилга Хот Байгуулалтын Сайдын баталсан 75 дугаар түр журмаар зөвхөн барилгын материалын үнэд магадлал хийж үнийн өсөлтийг тооцуулах чиглэл өгсөн ба Төсөл хэрэгжүүлэгч нэгж болон гүйцэтгэгч нарын | 1 | 2,970,083.0 | | | | | 1 | 2,970,083.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| төлөөлөл 2021 оноос хойш дээрх тогтоол, журмын дагуу зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг тооцуулах талаар уулзалтууд хийсэн боловч тодорхой үр дүн гараагүй, барилгын ажил зогсонги байна. | | | | | | | | | | | | |
| “Тэш Агь Констракшн” ХХК болон “Ай Ди Си Проперти” ХХК-ын түншлэл нь “Баянхошуу дэд төв дэх олон нийтийн хөгжлийн төвийн барилга угсралтын ажил” DDCD-BKH гэрээг 2021.02.25-ны өдөр байгуулж, гэрээний дүн 2,940,919.2 мянган төгрөг, гүйцэтгэх хугацааг 2021.02.25-2022.05.25-ны өдөр байхаар тусгасан боловч 2023.12.31-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 28 хувьтай бөгөөд тайлант онд барилгын ажил огт хийгдээгүй, гэрээг 2022.05.25-с хойш дахин сунгагдаагүй ба 2023.12.31-ны өдрийн байдлаар нийт 533,837.7 мянган төгрөгийн санхүүжилт | 1 | 3,582,044.4 | | | | | 1 | 3,512,044.3 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| авсан байна. Гүйцэтгэгчийн зүгээс ковид-19 цар тахлын улмаас хил, гааль хаагдсанаас үүдсэн барилгын бараа материал, цалин, тээвэр шатахуун, машин механизмтай холбоотой зардлаар үнийн өсөлт тооцуулах хүсэлт гаргаж тус ажлыг 6,522,963.6 мянган төгрөгийн шинэчилсэн төсөвт өртгөөр гүйцэтгэх боломжтой тухайгаа төслийн нэгжид 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдийн 23/31 тоот албан бичгээр мэдэгдсэн байна. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс дээрх төсвийн нэмэгдэл зөрүү 3,512,044.3 мянган төгрөгийг шийдвэрлэх боломжгүй, зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг шийдвэрлэх боломжтойгоо илэрхийлсэн боловч гүйцэтгэгчийн зүгээс хүлээн зөвшөөрөөгүй байна.Монгол Улсын Сангийн яам болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан 2022.07.08-ны өдрийн “ Санамж бичиг”-т давтагдашгүй хүчин зүйл ангилалд гэрээт ажлын зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг тооцож үзнэ гэж заасан, мөн Монгол Улсын Их Хурлын 88 дугаар тогтоол, Барилга Хот Байгуулалтын Сайдын баталсан 75 дугаар түр журмаар зөвхөн барилгын материалын үнэд магадлал хийж үнийн өсөлтийг тооцуулах чиглэл өгсөн ба Төсөл хэрэгжүүлэгч нэгж болон гүйцэтгэгч нарын төлөөлөл 2021 оноос хойш дээрх тогтоол, журмын дагуу зөвхөн бараа материалын үнийн өсөлтийг тооцуулах талаар уулзалтууд хийсэн боловч тодорхой үр дүн гараагүй, барилгын ажил зогсонги байна. | | | | | | | | | | | | |
| Тайлант онд 23,431,835.3 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Энэ нь тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна. | 1 | 23,431,835.3 | | | | | 1 | 23,431,835.3 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нийслэлийн санхүүжилтийн орлого 11,574,131.3 мянган төгрөг, тендерийн баримт бичиг борлуулсны орлого 37,009.5 мянган төгрөгийг тус тус цахим төлбөрийн баримтыг системд бүртгээгүй байна. | 1 | 11,611,140.8 | | | | | 1 | 11,611,140.8 | | | | |
| **Дүн** | **7** | **211,331,558.5** | **2** | **18,679.9** | **1** | **169,687,775.1** | **4** | **41,555,103.4** | **-** | **-** | **-** | **-** |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Тендерийн үнэлгээний хорооны гишүүд "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг бөглөхдөө өөр хүний нэр бичсэн мэдэгдэл дээр нэрийг дарж бичсэн зөрчил илэрсэн ба зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| *Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил* | | | | | | | | |
| Тендерийн үнэлгээний хорооны гишүүд "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг бөглөхдөө өөр хүний нэр бичсэн мэдэгдэл дээр нэрийг дарж бичсэн байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **1** | **-** | | | | | **1** | **-** |